



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА  
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Онцгой байдлын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн  
гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/04/-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Ховд хот  
2023 он

Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар  
Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn  
Аудитын менежер: А.Цэцэгсүрэн  
Утас: 70432545  
Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn  
Аудитор: Д.Эрдэнэцэцэг  
Утас: 99019943  
Цахим хаяг: erdenetsetseg.d@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

<b>1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ</b> .....	3
<b>2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ</b> .....	5
<b>3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА</b> .....	13
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....	13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд .....	14
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	15
<b>3.5.1 Төсвийн төлөвлөлт</b> .....	15
<b>3.5.2 Төсвийн гүйцэтгэл</b> .....	15
<b>3.5.3 Нэмэлт төсөв</b> .....	16
<b>4. АУДИТЫН ТАЙЛАН</b> .....	16
<b>4.1 Ерөнхий зүйл</b> .....	16
<b>4.2 Материаллаг байдал</b> .....	16
<b>4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт</b> .....	17
<b>4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал</b> .....	17
<b>4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт</b> .....	17
<b>4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт</b> .....	17
<b>4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн</b> .....	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	17
<b>5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ</b> .....	18
5.1 Залруулсан алдаа .....	18
5.2 Төлбөрийн акт .....	17
5.3 Албан шаардлага .....	17
5.4 Зөвлөмж .....	18
<b>6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ</b> .....	18

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ОБЕГ	Онцгой байдлын ерөнхий газар
ОБГ	Онцгой байдлын газар
ХШУДАГ	Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар

# 1 ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



**ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**  
84000 Цамбагарав бөг, Жаргалант сум, Ховд  
Утас: 976-70433061, Факс: 976-70433061  
E-mail: khovd@audit.gov.mn

ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН  
ДАРГА Б.АЛТАНБАДРАЛТ ТАНАА

2023.02.18 № 02/56  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

## Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Онцгой байдлын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Онцгой байдлын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

## Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

## Асуудлыг онцолсон хэсэг

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор асуудлыг онцолсон хэсэгт тайлант онд Бүсийн хэмжээнд тайлант нийт 895 удаагийн гамшиг осол, гал түймрийн дуудлага тохиолдож, 8 тэрбум 106.8 сая төгрөгийн хохирол учирч, 13 тэрбум 400 сая төгрөгийн хөрөнгийг авран хамгаалсан байна.

## Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсноор тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ нь аймгийн онцгой байдлын комиссоос нийлүүлсэн түргэвчилсэн оношлуурын тест нийлүүлсэн нь бараа материалын үлдэгдэл өсөхөд нөлөөлсөн байна.

## Бусад асуудлын хэсэг

АДБОУС 2706.10-д зааснаар аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүссэнгүй.

## Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

021020910

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЛДБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<u>1,379,132,597.63</u>	<u>1,644,710,945.79</u>
33	<b>АВЛАГА</b>	435,470.00	61,452.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	395,470.00	61,452.00
335	<b>Бусад авлага</b>	40,000.00	-
3351	Байгууллагаас авах авлага	40,000.00	-
35	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	1,378,697,127.63	1,644,649,493.79
351	<b>Түүхий эд материал</b>	885,834,083.03	934,851,233.03
35110	Тусгай зориулалттай материал	669,398,903.03	793,736,903.03
35130	Эм боох материал	216,435,180.00	141,114,330.00
354	<b>Хангамжийн материал</b>	490,893,044.60	707,828,260.76
35410	Бичиг хэргийн материал	1,393,125.00	2,024,128.76
35420	Аж ахуйн материал	43,613,059.00	46,346,259.00
35430	Сэлбэг хэрэгсэл	1,926,000.00	2,207,000.00
35440	Түлш, шатах тослох материал	11,089,900.60	3,615,000.00
35450	Барилгын засварын материал	495,000.00	4,585,000.00
35460	Хүнсний материал	127,500.00	-
35470	Бусад хангамжийн материал	432,248,460.00	649,050,873.00
35600	Мал амьтад	1,970,000.00	1,970,000.00
2	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<u>7,307,384,684.23</u>	<u>7,033,349,792.86</u>
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	7,307,384,684.23	7,033,349,792.86
392	<b>Биет хөрөнгө</b>	6,787,051,684.23	6,513,016,792.86
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,959,771,649.00	2,959,771,649.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(205,283,650.73)	(301,423,171.25)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	5,714,442,465.33	6,329,972,355.33
39204	Хуримтлагдсан элэгдэл	(1,913,565,901.81)	(2,791,885,369.33)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	437,259,538.68	447,578,108.09
39206	Хуримтлагдсан элэгдэл	(311,926,246.17)	(369,553,427.58)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	70,930,832.13	118,449,882.13

39208	Хуримтлагдсан элэгдэл	(40,140,019.56)	(39,512,491.45)
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	15,560,000.00	15,560,000.00
39212	Хуримтлагдсан элэгдэл	(15,560,000.00)	(15,560,000.00)
39214	Бусад үндсэн хөрөнгө	2,343,735.00	2,343,735.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(1,780,717.64)	(1,968,685.08)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	75,000,000.00	159,244,208.00
393	<b>Биет бус хөрөнгө</b>	520,333,000.00	520,333,000.00
39301	Програм хангамж	1,100,000.00	1,100,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,100,000.00)	(1,100,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	520,333,000.00	520,333,000.00
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<u>8,686,517,281.86</u>	<u>8,678,060,738.65</u>
4	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	-	7,886,273.00
41	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	-	7,886,273.00
413	<b>Өглөг</b>	-	7,886,273.00
4136	<b>Бусад өглөг</b>	-	7,886,273.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	7,886,273.00
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<u>8,686,517,281.86</u>	<u>8,670,174,465.65</u>
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	8,686,517,281.86	8,670,174,465.65
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,074,993,693.17	1,074,993,693.17
51101	Өмч: - төрийн	1,074,993,693.17	1,074,993,693.17
512	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	6,499,984,951.22	6,486,610,819.16
51210	Өмнөх үеийн үр дүн	6,499,984,951.22	6,502,953,635.37
51220	Тайлант үеийн үр дүн	-	(16,342,816.21)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,111,538,637.47	1,108,569,953.32
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<u>8,686,517,281.86</u>	<u>8,678,060,738.65</u>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	6,028,675,272.49	4,876,338,937.00
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	1,366,008,032.99	1,083,891,936.00
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	1,366,008,032.99	1,083,891,936.00

120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,366,008,032.99	1,083,891,936.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,366,008,032.99	1,083,891,936.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	4,662,667,239.50	3,792,447,001.00
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	3,138,275,700.00	3,354,294,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,138,275,700.00	3,354,294,800.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	1,524,391,539.50	438,152,201.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,403,979,689.50	388,419,730.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	116,166,850.00	39,018,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,245,000.00	10,714,471.00
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	5,353,393,477.69	4,892,681,753.21
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	5,353,393,477.69	4,892,681,753.21
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	5,352,077,477.69	4,872,681,753.21
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	2,682,287,065.00	2,689,148,969.00
210101	Үндсэн цалин	1,581,250,778.00	2,685,597,414.00
210102	Нэмэгдэл	1,040,193,768.00	3,551,555.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	60,842,519.00	-
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	72,222,290.00	74,111,949.00
210201	Тэтгэврийн даатгал	6,128,421.00	17,847,052.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,667,244.59	1,694,321.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,333,795.27	1,339,520.00
210204	Ажилгүйдлийн даатгал	342,686.95	338,865.00
210205	Эрүүл мэндийн даатгал	62,750,142.19	52,892,191.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	148,441,992.00	190,700,039.60
210301	Гэрэл, цахилгаан	32,079,110.00	42,752,897.00
210302	Түлш, халаалт	105,990,886.00	135,558,629.60
210303	Цэвэр, бохир ус	10,371,996.00	12,388,513.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	98,600,575.99	169,873,678.00
210401	Бичиг хэрэг	10,326,200.00	6,916,180.00
210402	Тээвэр, шатахуун	74,722,983.99	153,223,555.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	492,588.00	2,939,243.00

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	13,058,804.00	6,794,700.00
2105	<b>Нормативт зардал</b>	172,423,325.00	168,900,849.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	46,051,800.00	7,972,150.00
210502	Хоол, хүнс	126,371,525.00	160,928,699.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	34,966,231.00	211,355,759.00
210604	Урсгал засвар	34,966,231.00	211,355,759.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	5,166,300.00	4,925,200.00
210702	Дотоод албан томилолт	5,166,300.00	4,925,200.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	6,644,475.00	11,829,847.24
210803	Даатгалын үйлчилгээ	3,217,500.00	3,217,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	938,242.00	1,730,142.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	590,000.00	496,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,332,200.00	618,966.24
210807	Газрын төлбөр	566,533.00	5,767,239.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	2,131,325,223.70	1,351,835,462.37
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,860,000.00	649,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	848,465,165.20	1,047,317,722.37
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	1,316,000.00	20,000,000.00
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	1,316,000.00	20,000,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	20,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,316,000.00	-
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<u>675,281,794.80</u>	<u>(16,342,816.21)</u>
5	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<u>675,281,794.80</u>	<u>(16,342,816.21)</u>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<u>4,668,867,659.50</u>	<u>3,792,447,001.00</u>
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	4,668,867,659.50	3,792,447,001.00
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	3,138,275,700.00	3,354,294,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,138,275,700.00	3,354,294,800.00

1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	1,530,591,959.50	438,152,201.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,403,979,689.50	388,419,730.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	116,166,850.00	39,018,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,245,000.00	10,714,471.00
2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<u>4,581,867,659.50</u>	<u>3,670,102,793.00</u>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	4,581,867,659.50	3,670,102,793.00
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	4,573,601,759.50	3,642,296,493.00
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	2,677,928,400.00	2,688,013,700.00
210101	Үндсэн цалин	1,589,818,632.00	1,733,276,000.00
210102	Нэмэгдэл	1,040,193,768.00	907,910,700.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	47,916,000.00	46,827,000.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	73,612,500.00	74,873,200.00
210201	Тэтгэврийн даатгал	5,600,000.00	3,857,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,550,400.00	1,651,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,240,300.00	1,321,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	310,200.00	330,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	64,911,600.00	67,713,300.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	156,187,700.00	188,421,600.00
210301	Гэрэл, цахилгаан	27,423,300.00	29,943,600.00
210302	Түлш, халаалт	121,870,904.00	144,371,500.00
210303	Цэвэр, бохир ус	6,893,496.00	14,106,500.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	39,244,100.00	5,611,100.00
210401	Бичиг хэрэг	2,696,000.00	1,140,200.00
210402	Тээвэр, шатахуун	35,005,200.00	3,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,542,900.00	1,470,900.00
2105	<b>Нормативт зардал</b>	112,203,500.00	127,767,400.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	843,500.00	804,200.00
210502	Хоол, хүнс	111,360,000.00	126,963,200.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	25,498,900.00	174,438,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,133,000.00	3,308,100.00

210604	Урсгал засвар	21,365,900.00	171,130,000.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	5,166,300.00	4,925,200.00
210702	Дотоод албан томилолт	5,166,300.00	4,925,200.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	10,894,000.00	16,277,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	883,500.00
210803	Даатгалын үйлчилгээ	3,217,500.00	3,217,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	3,094,000.00	3,094,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	496,000.00	496,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,217,800.00	2,217,800.00
210807	Газрын төлбөр	1,868,700.00	6,368,700.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	1,472,866,359.50	361,968,693.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,524,400.00	8,060,700.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	8,265,900.00	27,806,300.00
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	8,265,900.00	27,806,300.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	8,265,900.00	27,806,300.00
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<u>87,000,000.00</u>	<u>122,344,208.00</u>
5	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	87,000,000.00	122,344,208.00
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	87,000,000.00	122,344,208.00
2200	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	87,000,000.00	122,344,208.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	87,000,000.00	122,344,208.00
6	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<u>(87,000,000.00)</u>	<u>(122,344,208.00)</u>
9	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	-
10	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	-

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	1,074,993,693.17	1,111,575,927.47	5,828,315,192.24	8,014,884,812.88
C02	Нягтлан бодох бүртгэлийн	-	-	-	-

	бодлогын өөрчлөлт				
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	1,074,993,693.17	1,111,575,927.47	5,828,315,192.24	8,014,884,812.88
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	675,281,794.80	675,281,794.80
C08	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	1,074,993,693.17	1,111,538,637.47	6,499,984,951.22	8,686,517,281.86
D01	<b>2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл</b>	1,074,993,693.17	1,111,538,637.47	6,499,984,951.22	8,686,517,281.86
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	2,968,684.15	2,968,684.15
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	1,074,993,693.17	1,111,538,637.47	6,502,953,635.37	8,689,485,966.01
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(2,968,684.15)	-	(2,968,684.15)
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(16,342,816.21)	(16,342,816.21)
D09	<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	1,074,993,693.17	1,108,569,953.32	6,486,610,819.16	8,670,174,465.65

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	3,354,294,800.00	3,354,294,800.00
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	3,354,294,800.00	3,354,294,800.00
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	3,326,488,500.00	3,326,488,500.00
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	2,688,013,700.00	2,688,013,700.00
210101	Үндсэн цалин	1,780,103,000.00	1,780,103,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	907,910,700.00	907,910,700.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	74,873,200.00	74,873,200.00
210201	Тэтгэврийн даатгал	3,857,300.00	3,857,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,651,200.00	1,651,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,321,000.00	1,321,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	330,400.00	330,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	67,713,300.00	67,713,300.00

2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	195,121,600.00	195,121,600.00
210301	Гэрэл, цахилгаан	29,943,600.00	29,943,600.00
210302	Түлш, халаалт	151,071,500.00	151,071,500.00
210303	Цэвэр, бохир ус	14,106,500.00	14,106,500.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	5,611,100.00	5,611,100.00
210401	Бичиг хэрэг	1,140,200.00	1,140,200.00
210402	Тээвэр, шатахуун	3,000,000.00	3,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,470,900.00	1,470,900.00
210404	Ном, хэвлэл	-	-
2105	<b>Нормативт зардал</b>	127,767,400.00	127,767,400.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	804,200.00	804,200.00
210502	Хоол, хүнс	126,963,200.00	126,963,200.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	-
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	205,838,100.00	205,838,100.00
210604	Урсгал засвар	205,838,100.00	205,838,100.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	4,925,200.00	4,925,200.00
210702	Дотоод албан томилолт	4,925,200.00	4,925,200.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	16,277,500.00	16,277,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	883,500.00	883,500.00
210803	Даатгалын үйлчилгээ	6,311,500.00	6,311,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	496,000.00	496,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	2,217,800.00	2,217,800.00
210807	Газрын төлбөр	6,368,700.00	6,368,700.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	8,060,700.00	8,060,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,060,700.00	8,060,700.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	27,806,300.00	27,806,300.00
2131	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	-	-
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	-
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	27,806,300.00	27,806,300.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	27,806,300.00	27,806,300.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	3,354,294,800.00	3,354,294,800.00
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	3,354,294,800.00	3,354,294,800.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	3,354,294,800.00	3,354,294,800.00
4	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	-
5	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	-

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	
I	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	438,152,201.00
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	438,152,201.00

210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	438,152,201.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	427,437,730.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	427,437,730.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,714,471.00
II	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	438152201.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	438,152,201.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	388,419,730.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	39,018,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	10,714,471.00
IV	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Онцгой байдлын газар нь Монгол Улсын Үндсэн хууль, Онцгой байдлын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж, дээд шатны байгууллага, албан тушаалтны тогтоол, шийдвэр, тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбоотой хөтөлбөр, төлөвлөгөө, хуулиар хүлээсэн үндсэн чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- ✓ *Нутаг дэвсгэртээ хууль тогтоомжийг хэрэгжүүлэх*
- ✓ *Засгийн газрын шийдвэр болон харьяалах дээд шатны шийдвэрийг гүйцэтгэлийг хянах*
- ✓ *Харьяа яамны сайдын тушаал, шийдвэрийг хэрэгжүүлэх*

ОБЕГ-ын 2018 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/478 тоот тушаалаар Онцгой байдлын газрыг 193 орон тоотой байхаар баталсан байна. Онцгой байдлын газар нь удирдах 2, гүйцэтгэх албан тушаалтан 172, үйлчилгээний 21 албан хаагчидтайгаар үйл ажиллагаа явуулж батлагдсан орон тоогоор ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөх хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ✓ *Төрийн хэмнэлтийн тухай хууль*

Онцгой байдлын газар нь 2022 онд хүний эрхийг дээлэн, үйл ажиллагаандаа иргэдийн оролцоо, дэвшилтэд технологийн ашиглалтыг нэмэгдүүлэн албан хаагчдын эрүүл мэнд, хууль ёсны эрх ашгийг хамгаалж хүний нөөцийн тогтвортой байдлыг бүрдүүлж ажиллана гэсэн зорил дэшүүлэн, гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган үр дүнг тооцон ажилласан байна.

Бүсийн хэмжээнд тайлант нийт 895 удаагийн гамшиг осол, гал түймрийн дуудлага тохиолдож, 8 тэрбум 106.8 сая төгрөгийн хохирол учирч, 13 тэрбум 049.4 сая төгрөгийн хөрөнгийг авран хамгаалсан байна.

Бүсийн Онцгой байдлын газрын даргын тушаалаар бүсийн нэгдсэн сургалтыг 4 удаа албаны өндөржүүлсэн бэлэн байдалд 8 удаа шилжүүлж, Онцгой байдлын ерөнхий газраас цаг агаарын аюулт үзэгдлээс урьдчилан сэргийлэх шуурхай мэдээ, болзошгүй гамшиг осол,

аюулт үзэгдлээс урьдчилан сэргийлэх, албаны бэлтгэл бэлэн байдлыг дээшлүүлэх тухай 21 удаагийн үүрэг чиглэл өгч удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллажээ.

Монгол улсын Засгийн газар, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх, орон нутгийнхаа эдийн засаг, нийгмийн хөгжилд онцгой ахиц дэвшил гарган аймгийн 2018, 2019, 2020, 2021 оны "ТЭРГҮҮНИЙ ШИЛДЭГ БАЙГУУЛЛАГА" болсон байна.

### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Тус байгууллага нь Захиргааны ерөнхий хууль, Гамшгийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Онцгой байдлын албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль зэрэг бусад хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт **үр нөлөөтэй** байна.

Байгууллагын даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг тус байгууллагын өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавин ажиллаж байна. Тайлант онд тус ажлын хэсэг 2 ажлыг төлөвлөн хэрэгжүүлжээ. Шадар сайдын албанаас дотоод аудит, хяналт, шинжилгээ үнэлгээний газраас тус онд дотоод хяналт шалгалт хийгдсэн байна.

Тайлант онд ТӨБЗГ-ын 2022 оны 02 дугаар 22-ны өдрийн 64 дүгээр тогтоолын дагуу ОБГ-ын даргын 2022 оны 12 дугаар сарын 02-ны А/65 дугаар тушаалаар төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг, тооллогын ажлыг зохион байгуулах ажлын хэсэг 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр томилж, тооллогыг зохион байгуулж хөрөнгө бүртгэн авах, актлах хөрөнгийг шийдвэрлүүлэх талаар санал дүгнэлтийг гаргажээ.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах **шаардлагагүй** гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Онцгой байдлын газар нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад **нийцсэн** тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Онцгой байдлын газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 8.4 сая төгрөгөөр буюу 0.1 хувиар буурсан байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	435.5	61.5	(374.0)
Бараа материал	1,378,697.1	1,644,649.5	265,952.4
Үндсэн хөрөнгө	7,307,384.7	7,033,349.8	(274,034.9)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>8,686,517.3</b>	<b>8,678,060.8</b>	<b>(8,456.5)</b>
Өр төлбөр	-	7,886.3	7,886.3
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	8,686,517.3	8,670,174.5	(16,342.8)
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>8,686,517.3</b>	<b>8,678,060.8</b>	<b>(8,456.5)</b>

Дээрх хүснэгтээс харахад дансны үлдэгдэлд гарсан дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- ✓ Сумдыг халаалтын шугамтай холбосонтой холбоотой 7.9 сая төгрөгийн халаалтын өр үүссэн байна.
- ✓ Бараа материалын дансанд ОБЕГ-аас тусгай зориулалтын 432.6 сая төгрөгийн материал үнэ төлбөргүйгээр бүртгэж авснаар бараа материалын үлдэгдэл өсөхөд нөлөөлсөн байна.
- ✓ Үндсэн хөрөнгийн зардал ТӨБЗГ-ын 706 тоот тогтоолоор үлдэх өртөггүй хөрөнгө акталсан, элэгдлийн зардалтай холбоотой буурсан байна.
- ✓ Авлага өмнөх оноос 374.0 мянган төгрөгөөр буурсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 3365.8 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 10.9 сая төгрөгөөр бууруулж 3354.3 сая төгрөгөөр баталсан байна. Энэ нь 2022 оны төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүй эсвэл өмнөх оны төсвийн гүйцэтгэлд үндэслэснээс шалтгаалсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг тодотгоогүй байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 3354.3 сая төгрөгийг улсын төсвөөс бүрдүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 3354.3 сая төгрөгийн орлого бүрдүүлж 3354.3 сая төгрөг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3354.3 сая төгрөг буюу 100 хувьтай зарцуулсан байна.

## Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	70704/80101-Зардал	3,346,234.1	3,346,234.1	-	100
2	70711/80802-ХҮДХ	8,060.7	8,060.7	-	100
<b>ДҮН</b>		3,354,294.8	3,354,294.8	-	100

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар ЗДТГ-аас 261.9 сая, ИТХ-аас 1.5 сая, ЖСЗДТГ-аас 20.0 сая, ХХС-аас 64.2 сая ОНХО-аас 38.0 сая, ОБЕГ-аас 52.6 сая нийт 438.2 сая төгрөгийн орлого орж гамшгийн зардалд 314.5 сая, хөрөнгө оруулалтын зардалд 84.2 сая, урсгал засварын зардалд 38.0 сая нийт 438.2 сая төгрөг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Онцгой байдлын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн хөрөнгө, материалтай холбоотой зөвлөмж тусгасан.

Аудитыг аудитор Д.Эрдэнэцэцэг 2023 оны 02 дүгээр сарын 15-наас 02 дүгээр сарын 18-ний хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 35/21 албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт зардлын 4581.8 сая төгрөгөөс 1 хувиар буюу 45.8 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 60 хувиар буюу 27.4 сая төгрөгөөр тогтоосон.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага хуулиар хориглосон зардлуудыг санхүүжүүлээгүй байна.

8 дугаар зүйлд заасан дүрэмт хувцастай холбоотой тус газраас зардал гараагүй бөгөөд ОБЕГ-ын хангалтын 115-р ангиас офицер, ахлагч нарын 318.9 сая төгрөгийн хувцас ирж бараа материалд үнэ төлбөргүй орлогоор бүртгэн авсан байна.

9 дүгээр зүйлд заасан албан томилолтын хувьд тус байгууллага нь 2022 онд 5.1 сая төгрөгийн томилолтын зардлыг давхардсан тоогоор 87 албан хаагчид олгосон байна. Энэ нь гүйцэтгэх албан тушаалтан Улаанбаатар хотод мэргэжлийн сургалтад оролцох, албан хаагчид авран хамгаалах бүсэд ажиллах, хамгаалалтад гарах, хяналт шалгалт хийх зэрэг ажлаар ажилласан байна.

13 дугаар зүйлд заасан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд Хөшөөт хөгжил сангаас 84.2 сая төгрөгийн сургалтын төв барих санхүүжилт ирж ажлаа хугацаандаа хүлээлгэж өгөөгүйгээс санхүүгийн тайланд дуусаагүй үйлдвэрлэлийн орлогоор бүртгэсэн.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 152 мэдээллээс хугацаандаа оруулсан 152 мэдээлэл бүрэн оруулж хугацаа хоцроосон мэдээлэл байхгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### **4.5 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх оны аудитаар акт, албан шаардлага, зөвлөмж өгөгдөөгүй байна.

### **4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар авч үзэх, анхаарал хандуулахуйц асуудал нь хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэл, түргэвчилсэн оношлуурын зарцуулалтыг авч үзэх шаардлагатай гэж үзлээ.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 122.3 сая төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс 122.3 сая төгрөгийн алдааг залрууллаа. Үүнд:

### 5.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд орлого бүрэн тусгаагүй, хөрөнгө оруулалтаар ирсэн санхүүжилтийг авлагаар тусгаж тайлагнаагүй байгаад дараах залруулга хийгдлээ. Үүнд:

#### 5.1.1 Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой

- ✓ Төсвөөс үндсэн хөрөнгө бэлтгэсэн 122.4 сая төгрөг үр дүнгийн тайланд зөрүүтэй илэрхийлэгдсэн байгааг залруулсан. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-т "Аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх" заалтыг зөрчсөн байна.

Аудитаар дахин давтан гаргахгүй байх 1 заалт бүхий зөвлөмж өглөө.

### 5.2 Төлбөрийн акт

Төлбөрийн акт бичигдээгүй

### 5.3 Албан шаардлага

Албан шаардлага өгөгдөөгүй

### 5.4 Зөвлөмж

Зөвлөмж өгөгдсөнгүй

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Жинхэнэ зарлага зөрүүтэй илэрхийлэгдсэн	1	122.3			1	122.3	1	122.3				
Дүн	1	122.3			1	122.3	1	122.3				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/ мянган төгрөг/

Зөрчлийн товч утга	Үүнээс							
	Нийт алдаа		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Алдаа илэрсэнгүй								
Дүн	-	-	-	-	-	-	-	-

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан/, тэмдэглээгүй орхисон/.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Алдаа илрээгүй	-	-	-	-	-	-	-	-
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Алдаа илрээгүй								
Дүн								
Нийт дүн								

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  Х.БОЛДБААТАР

АУДИТЫН МЕНЕЖЕР:  А.ЦЭЦЭГСҮРЭН

ТАЙЛАНГ БИНСЭН:

АУДИТОР:  Д.ЭРДЭНЭЦЭЦЭГ





**БАРУУН БҮСИЙН ТӨВ  
ХОВД АЙМГИЙН  
ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗАР**

84149 Наран баг, Жаргалант сум, Ховд аймаг  
Утас/факс: 7043-2201  
E-mail: khovd\_emerg@yahoo.com

тэнгэйн № \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т  
*Б.Алтанбадралт* 25/12

Г

Г

**ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН  
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА Х.БОЛДБААТАР  
ТАНАА**

Тус газрын тайлант оны санхүүгийн тайланд  
122.3 сая төгрөгийн залруулга хийсэн болно.

**ДАРГА,  
ХУРАНДАА**

**Б.АЛТАНБАДРАЛТ**



G:\2023-А5\ЖИЖИГ ТООТ.DOCX